



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2025 оны 10 сарын 17 өдөр

Дугаар А/54

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, 8.4 дэх хэсэг, 2025 оны 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-ын 3.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хүрээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Улсын Их Хурлын тогтоол, Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэр, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл болон албан даалгаврын хэрэгжилтэд давхардал, хийдлийн судалгаа хийж, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ахлагч:	Н.Ганболд	Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга
Гишүүд:	Х.Энхчимэг	Захиргаа, удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн
	Э.Ганчимэг	Төрийн өмчийн хяналт, шалгалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн
	Б.Амарбаясгалан	Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн
	Р.Ширчинням	Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн мэргэжилтэн
	Х.Нарангарав	Хууль эрх, зүйн хэлтсийн мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга:	Д.Цэрэнлхам	Захиргаа, удирдлагын хэлтсийн мэргэжилтэн

2.Ажлын хэсгийн удирдамжийг хавсралтаар баталсугай.

3.Удирдамжийн дагуу судалгаа хийж, дүгнэлт тайланг 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн дотор танилцуулахыг Ажлын хэсэг (Н.Ганболд)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

132063289

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын Албаны 40 сарын 47-ны өдрийн 154 дугаар тушаалын хавсралт

ДЭЭД ГАЗРЫН ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТЭД СУДАЛГАА ХИЙЖ, ДҮГНЭЛТ ГАРГАХ ҮҮРЭГ БҮХИЙ АЖЛЫН ХЭСТИЙН УДИРДАМЖ

НЭГ. Нийтлэг үндэслэл, зорилго:

1.1. Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-ын 3.10 дахь заалт “Байгууллага, албан тушаалтан дараах тохиолдолд шийдвэрийг хяналтаас хасах тухай саналыг Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлнэ”, мөн дээрх тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Үнэлгээ хийх журам”-ын 9.2 дахь заалт “Байгууллага бодлогын баримт бичгийн үнэлгээний тайлан, шийдвэрлэх асуудлыг байгууллагын удирдлагын зөвлөл (баг)-д хэлэлцүүлж, шийдвэрийн дагуу зохих арга хэмжээ авна. Байгууллага дотооддоо шийдвэрлэх боломжгүй асуудлыг ажлын 10 өдөрт багтаан дээд шатны байгууллагад хүргүүлж, шийдвэрлүүлнэ”, Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2025 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн хэг/2738 дугаар албан бичгийг тус тус үндэслэн удирдлага болгов.

1.2. Дээд газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн үр дүнгээр бодит шалтгааны улмаас хэрэгжих боломжгүй болсон, цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон, тухайн шийдвэр хүчингүй болсон, шийдвэрт заасан хугацаа дууссан, байгууллагын чиг үүрэгт хамааралгүй болсон шийдвэрүүдийг судалж, түүнд дүгнэлт гарган Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж, Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сангийн хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн нэгдсэн системийн хяналтаас хасуулах.

ХОЁР. Хамрах хүрээ, хугацаа:

2.1. Улсын Их Хурлын тогтоол, Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэр, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл болон албан даалгавар

2.2. 2025 оны 10 дугаар сарын 17-ны өдрөөс 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн хооронд зохион байгуулна.

ГУРАВ. Зохион байгуулалтын талаар:

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн судалгааны хүснэгтийн дагуу ажлын хэсгийн нарийн бичгийн дарга Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сангийн хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хяналтад байгаа эрх зүйн актын жагсаалтыг гаргаж, ажлын хэсгийн гишүүдэд хүргүүлнэ.

Ажлын хэсгийн гишүүд холбогдох шийдвэрийг заалт тус бүрээр шалтгаан, тайлбарын хамт гаргаж, ажил үүргийн хуваарийн дагуу гүйцэтгэнэ.

Судалгаанд үндэслэн санал дүгнэлт боловсруулан ажлын хэсэг, удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.

Дөрөв. Ажил үүргийн хуваарь

д/д	Чиг үүрэг	Хугацаа	Хариуцах эзэн
1	Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж, Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сангийн хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хяналтад байгаа эрх зүйн актын жагсаалтыг хариуцах хэлтсээр нь ангилан ажлын хэсгийн гишүүдэд хүргүүлэх	2025.10.17 2025.10.20	Д.Цэрэнлхам
2	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хяналтад байгаа эрх зүйн актын жагсаалтаас холбогдох шийдвэрийн заалтыг судалгааны хүснэгтийн дагуу гаргах	2025.10.21 2025.10.27	Х.Энхчимэг Э.Ганчимэг Б.Амарбаясгалан Р.Ширчинням Х.Нарангарав
3	Хэлтсүүдээс ирүүлсэн судалгааны хүснэгтийг нэгтгэн санал, дүгнэлт боловсруулан, удирдлагын зөвлөлд танилцуулж, холбогдох газарт хүргүүлэх	2025.10.28 2025.10.31	Н.Ганболд Д.Цэрэнлхам